



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 297

Улаанбаатар хот

“Финанс линк групп” ХХК-ийн андеррайтерийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 8.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Финанс линк групп” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсонтой холбогдуулан тус компанийн андеррайтерийн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтыг “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 9.3-т заасны дагуу архивын нэгж болгон цэгцлэж, 2012 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Хорооны архивт хүлээлгэн өгөхийг “Финанс линк групп” ХХК /Б.Болормаа/-д үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд хүчингүй болгох бичилт хийж, холбогдох баримт хүлээлцэх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

002395